



2022 онд гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтний нийт Монгол ажиллагчдын тоонд эзлэх хувь, хэмжээ

Монгол Улсын Засгийн газар (“Засгийн газар” гэх) Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагуудын гадаадаас авах ажилтны хувь хэмжээг жил бүр шинэчлэн тогтоодог билээ. 2022 онд авах ажиллах хүч, мэргэжилтний эзлэх хувийг 2021 оны 11 дүгээр сарын 3-ны өдрийн 339 тоот тогтоолоор (“Засгийн газрын 339-р тогтоол” гэх) Засгийн Газар нь шинэчлэн тогтоолоо.

Холбогдох хаяг:

Майкл Ахэрн

Партнер, Татвар, Хуулийн зөвлөх үйлчилгээ
michael.ahern@pwc.com

Чойжамцын Цэндмаа

Гүйцэтгэх захирал, Татвар, Хуулийн зөвлөх үйлчилгээ
tsendmaa.choijamts@pwc.com

Рагчаахүүгийн Мөнхжаргал

Хуулийн үйлчилгээ хариуцсан менежер
munkhjargal.ragchaakhuu@pwc.com

ПрайсвотэрхаусКүүпэрс Такс ТМЗ ХХК

Өмгөөллийн ПрайсвотэрхаусКүүпэрс Легал ХХН

Сентрал Тауэр, 6 давхар
603 тоот, Улаанбаатар
14200, Монгол улс
Утас : + 976 70009089
Факс : +976 11 322068

www.pwc.com/mn

2022 онд гадаад ажилтны эзлэх хувь хэмжээ нь эдийн засгийн үйл ажиллагааны салбар чиглэл болон Монгол ажилтны тооноос шалтгаалан 10%-60% байхаар тогтоосон. Засгийн газрын 339-р тогтоолд урьдын адил тусгайлан заагаагүй салбарын хувьд 20-оос дээш монгол ажилтантай компаниудын гадаадын нийт ажилтны тоо нь Монгол ажилтны тооны 5%-иас хэтрэхгүй байна.

Өмнө оны Засгийн газрын 128-р тогтоолоор (2021 онд гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтний нийт Монгол ажиллагчдын тоонд эзлэх хувь, хэмжээ) гадаадын хөрөнгө оруулалттай компанийн хувьд удирдах бүрэлдэхүүний 3 төлөөлөгч, хөрөнгө оруулагч/хувьцаа эзэмшигч 1 хүн энд заасан хувь хэмжээнд хамаарахгүй гэсэн зохицуулалттай байсан. Харин 339 дүгээр тогтоолын дагуу олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн газарт ажиллах 2 гадаадын иргэнд олон улсын байгууллагын тодорхойлолтыг үндэслэн энэ тогтоолд заасан хувь, хэмжээнд хамааруулалгүй хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгож болно.

Улсын хэмжээний эсхүл томоохон төсөлд олон тооны ажилтан гадаадаас ажиллуулах шаардлагатай этгээдийн хувьд Засгийн газраас шийдвэр гаргасан тохиолдолд дээрх хувь хэмжээ хамаарахгүй, мөн ажлын байрны сар бүрийн төлбөрөөс чөлөөлөгдөх боломжтой.

Засгийн газрын 339-р тогтоолоор ихэнх эдийн засгийн салбаруудын гадаад ажилтны эзлэх хувь хэмжээ нь өмнөх онд тогтоосон хувь хэмжээнээс өөрчлөгдөөгүй. Харин сургуулийн өмнөх боловсрол олгох үйл ажиллагааг (сургуулийн өмнөх, бага, дунд боловсролын нийт хувь хэмжээ 50% байсан) жагсаалтаас хассан ба 2022 оны бага, дунд боловсролын хувь хэмжээг тус тус 10%, 20% байхаар тогтоосон байна. Нөгөөтэйгүүр, зарим эдийн засгийн салбаруудыг жагсаалтад нэмсэн байна. Үүнд:

- Цахилгаан эрчим хүч, дулаан үйлдвэрлэл, дамжуулах, түгээх үйл ажиллагаа (хувь хэмжээ 10 - 40%);
- Нийтийн хоолны газрын үйл ажиллагаа (хувь хэмжээ 15 - 30%);

Зочид буудал, байр, сууцаар үйлчлэх үйл ажиллагааны хувь хэмжээ өмнө онд 10% байсан бол 5 - 20%-аар өссөн, металл боловсруулах үйлдвэрлэл өмнө онд 15% байсан бол 50% болж огцом өсөлт үзүүлсэн байна. Засгийн газар хоорондын гэрээтэй болон гадаадын хөрөнгө оруулалттай олон улсын хөтөлбөрөөр сургалт явуулдаг боловсролын байгууллагын хувь хэмжээ өмнөх оныхоос 20%-аар буурч 50% болсон байна.

Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн төслийг Улсын Их Хурал хэлэлцэж байгаа байгаа бөгөөд уг хуулийн төсөлд гадаад ажилтны тоог тодорхойлодог аргачлал болон гадаад ажилтанд олгох хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийн процедурыг өнөөгийн практикаас өөрөөр зохицуулахаар заасан байна. Уг хууль батлагдаж, олон нийтэд ил болмогц бид хуулийн өөрчлөлтийн талаарх мэдээллийг үйлчлүүлэгчиддээ хүргэх болно.

Дэлгэрэнгүй мэдээллийг доорх линкнээс авна уу.

<https://legalinfo.mn/mn/detail/16381557161751>

Энэхүү мэдээлэлтэй холбоотой нэмж тодруулах зүйл байвал бидэнтэй холбогдоно уу.

Энэхүү мэдээллийг ПрайсвотэрхаусКүүпэрс Такс ТМЗ ХХК болон Өмгөөллийн ПрайсвотэрхаусКүүпэрс Легал ХХН-өөс бэлтгэсэн болно. Энэ мэдээлэлд багтсан материал нь зөвхөн ерөнхий мэдээллийн зорилготой бөгөөд энд тусгасан асуудал бүрээр олон талын, цогц шинжилсэн мэдээллийг агуулаагүй болно. Аливаа үйлдэл хийх (эс үйлдэх)-ээс өмнө үүнийг уншигч та өөрийн нөхцөл байдалд тохирсон тусгайлан мэргэжлийн зөвлөгөө авах нь зүйтэй. Энэ мэдээллийн агуулгыг ашигласан үйлдэл, алдаа хийдлээс гарах аливаа хариуцлагыг бид хариуцахгүй болно.

